



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 06 сарын 07 өдөр

Дугаар 07/184

Мандалговь

"Топ дриллинг" ХХК-тай гэрээ байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй "Олгойн говь-1 орд газарт шинээр гүний худаг гаргаж, цахилгаан хангамж, цэвэр усны дамжуулах шугамын ажил"-ын гүйцэтгэгчээр шалгарсан "Топ дриллинг" ХХК-тай 245,374,849 (хоёр зуун дөчин таван сая гурван зуун далан дөрвөн мянга найман зуун дөчин ес) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

2. Батлагдсан зураг, төсвийн дагуу "Олгойн говь-1 орд газарт шинээр гүний худаг гаргаж, цахилгаан хангамж, цэвэр усны дамжуулах шугамын ажил"-ыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг "Топ дриллинг" ХХК-ийн захирал (Л.Пүрэвдорж)-д үүрэг болгосугай.

3.Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Энхтайван) нарт үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
TYP ORLOH GUYJCETGEGCH

И.ДОРЖБАТ

ДОРЖБАТ

4832150387